



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 2 сарын 21 өдөр

Дугаар 39


Улаанбаатар хот

Журам, жишиг баримт бичиг  
батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7<sup>1</sup> дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмыг 1 дүгээр хавсралтаар, Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны жишиг баримт бичгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Х.Ганцогт/, Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс /Э.Хангай/-т тус тус даалгасугай.

САЙД



Ч.УЛААН

000158

## **ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТОЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

### **Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид хууль гэх/-ийн 7<sup>1</sup> дүгээр зүйлд заасны дагуу сум, дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах хорин сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааг зохион байгуулах, зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Олон нийтийн оролцоотой бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад Сангийн сайдын 2012 оны 02 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан “Журам, жишиг баримт бичиг батлах тухай” 39 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батласан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны жишиг баримт бичиг”-ийг хэрэглэнэ.

1.3. Энэхүү журмаар зохицуулагдаагүй харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль түүнд нийцүүлэн батлагдан гарсан заавар, журмын дагуу зохицуулна.

1.4. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд тендерт оролцогч нь Иргэний хуулийн шаардлага хангасан хамтран ажиллах гэрээний үндсэн дээр байгуулагдсан иргэдийн бүлэг /цаашид “бүлэг” гэх/ байна.

### **Хоёр. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааг зохион байгуулах**

2.1. Сум дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах хорин сая хүртэлх төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотой сонгон шалгаруулахдаа захиалагч нь хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээний хороо байгуулна.

2.2. Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3.3-58.3.7, 58.4.3-58.4.8 дугаар заалтад заасан төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмын дагуу зохион байгуулж болно. Дээрх заалтуудад заасан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байна.

2.3. Сум дүүргийн төсвийн хүрээнд олон нийтийн оролцоотой зохион байгуулагдах худалдан авах ажиллагаанд оролцохыг хүссэн иргэд Иргэний хуулийн дагуу хамтран ажиллах гэрээ байгуулж, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүсэлтээ гаргана.

2.4. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд оролцох сонирхолтой бүлгээс ирүүлсэн хүсэлтэд үндэслэн “Иргэдийн бүлгийн жагсаалт”-ыг бэлтгэнэ. Уг жагсаалтад бүлгийг үндэслэлгүйгээр бүртгэхээс татгалзахыг хориглоно.

2.5. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь “Иргэдийн бүлгийн жагсаалт”-ыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан иргэдэд нээлттэй байлгана.

2.6. Энэхүү журмын 2.3-т заасан жагсаалтаас бүлэг өөрийн саналаар гарах, шинээр орох эрхийг энэхүү журмаар хязгаарлахгүй.

2.7. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааг зохион байгуулахад энэ журмын 2.3 дахь хэсэгт заасан жагсаалтад багтсан гурав болон түүнээс дээш бүлэгт үнийн санал авах урилгыг албан бичгээр, цахим шуудангаар хүргүүлэн, товлосон хугацаанд хүлээн авч, үнийн саналын нээлт хийж, харьцуулалтын аргаар шалгаруулна.

2.8. Захиалагч нь санал авах урилга тараасан хугацаанаас хойш хүлээн авах эцсийн хугацааг ажлын 5 /тав/-аас доошгүй хоногоор тогтооно.

2.9. Санал авах урилга хүлээн аваагүй боловч тухайн ажлыг гүйцэтгэх чадвартай бүлэг оролцох хүсэлтээ бичгээр гаргасан тохиолдолд түүнийг тухайн шалгаруулалтад оролцуулахаас татгалзаж үл болно.

2.10. Санал авах баримт бичгийг сонирхсон этгээдэд цаасан болон цахим хэлбэрээр саадгүй олгоно.

2.11. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд шаардлагад нийцсэн үнийн санал ирээгүй тохиолдолд бүх тендерээс татгалзаж хуулийн 33 дугаар зүйлийн 33.4-т заасныг захиалагч мөрдөж ажиллаж болно.

### **Гурав. Худалдан авах ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах**

3.1. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд оролцохдоо бүлэг нь хамтран ажиллах гэрээний эх хувийг нотариатаар батлуулан ирүүлнэ.

3.2. Хамтран ажиллах гэрээнд дараахь зүйлсийг заавал тусгасан байвал зохино. Үүнд:

- 3.2.1. Гэрээний талуудын нэр, хаяг;
- 3.2.2. Хамтын үйл ажиллагааны төрөл, зорилго;
- 3.2.3. Талуудын эрх, үүрэг;
- 3.2.4. Удирдлагын бүтэц, эрх, үүрэг;
- 3.2.5. Ашиг, алдагдлыг хуваарилах журам;
- 3.2.6. Гэрээнээс гарах журам;
- 3.2.7. Гэрээний хугацаа;
- 3.2.8. Гэрээг дуусгавар болгох үндэслэл, дундын эд хөрөнгийг хуваарилах журам.
- 3.2.9. Бүлгийн ахлагч, гишүүдийг тус бүр томилсон байх;
- 3.2.10. Бүлгийн бүх гишүүн хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг хамтран ажиллах гэрээнд тодорхойлсон байх;
- 3.2.11. Бүлгийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авах, төлбөр тооцоо хийхэд тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилох;

Хамтран ажиллах гэрээний үндэслэл

3.2.12. Нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөрийг зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй тооцохыг хамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байх.

3.3. Бүлэг хамтран ажиллах гэрээг хүсэлтийн хамтаар сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, “Иргэдийн бүлгийн жагсаалт”-д бүртгүүлснээр олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй болох бөгөөд хуульд заасан журам, зааврыг мөрдөж ажиллах үүрэгтэй.

3.4. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газраас олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд үнийн санал ирүүлэх урилга хүлээн аваагүй бүлэг хүсэлт гарган тус худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй.

### **Дөрөв. Хяналт, Шалгалт**

4.1. Захиалагч болон бусад хууль, хяналтын байгууллага, иргэд нь олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

4.2. Захиалагч олон нийтийн оролцоотой худалдан авах гэрээний хэрэгжилтэд хяналт тавихдаа гүйцэтгэлийн хянагчаар зөвхөн тухайн сум, дүүрэгт бүртгэлтэй иргэдээс сонгон томилно.

4.3. Гүйцэтгэлийн хянагч гэрээний хэрэгжилтийн хяналтыг өдөр тутам гүйцэтгэх бөгөөд захиалагч хууль, журамд нийцүүлэн урамшуулал олгож болно.

4.4. Захиалагч хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дах хэсэгт заасны дагуу архивын нэгжийг үүсгэхдээ тухайн орон нутгийн арваас доошгүй иргэдээс гэрээний гүйцэтгэлд өгсөн сэтгэл ханамжийн дүн, үнэлгээний судалгааг авч хавсаргана.

### **Тав. Хариуцлага**

5.1. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа энэхүү журмын зүйл, заалтыг зөрчсөн этгээдэд хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага ногдуулна.

5.2. Тендерт оролцогч болон аливаа этгээд олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ зөрчсөн, биелүүлээгүй, илт худал мэдээлэл ирүүлсэн, авилгын гэмт хэрэгт холбогдсоныг шүүх, эрх бүхий улсын байцаагч тогтоосон бол хуулийн 57 дугаар зүйлийн 57.5-д заасан эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулна.

**\*\*\*\*\***